



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРХОНТУУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ

2021.12.24

Баянцогт

### **Нэг.ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:**

Аймгийн ажлын хэсэг суманд 2021 оны 12-р сарын 18-ны өдөр ирж ажиллан Ковид болон Шүлхий өвчний талаар авч хэрэгжүүлсэн ажил арга хэмжээтэй танилцан сайжруулах шаардлагатай ажлууд дээр зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж хамтарч ажиллалаа.

Өвчлөл бүртгэгдсэн өдрөөс эхлэн нийт **9** голомтод **69** өрхийн **846** үхэр болон **260** бог нийт **1106** малд гоц халдварт А01 өвчний шинж тэмдэг илэрч, ээмэгжүүлэн бүртгэлжүүлсэн байна. Шинж тэмдэг арилсан 65 өрхийн 773 үхэр, 260 бог нийт 1033 мал байна.

Шүлхий өвчний талаарх мэдээ тайланг Аймгийн Онцгой комисс болон Аймгийн Мал эмнэлэгийн газарт өдөр бүр 18:00 цагт хүргүүлэн ажиллаж байна.

Явуулын хөдөлгөөнт болон Морьт эргүүл хийх хуваарь гарган голомтын бүсээр тогтмол эгүүл хийж ажиллаж байна.

2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр сумын ИТХурал нэгдсэн хуралдаан зохион байгуулж хурлаар Сумын Засаг даргын 2021 оны Хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийг тайлаган үр дүнг тооцуулж ажиллалаа.

### **Мэдээлэл сурталчилгааны чиглэлээр:**

Тогтвортой амжиргаа-3 төслөөс сумын төр төсвийн байгууллагын албан хаагчид, иргэд, ИТХ-ын төлөөлөгч нарт ОНХС-ын зохион байгуулалтын талаарх сургалтыг 12 дугаар сарын 15-ны өдөр суманд танхимаар зохион байгууллаа. Сургалтанд нийт 46 иргэн хамрагдлаа.

Хүний эрхийн өдрийг тохиолдуулан Эрх зүйн хөтөчийн булангаар иргэдэд хууль эрх зүйн зөвлөгөө өгх нээлттэй өдөрлөгийг зохион байгуулж 10 иргэнд тулгамдсан асуудал дээр хуулийн зөвлөгөө өгч нийт 46 иргэнд гарын авлага тарааж ажиллалаа.

Эрх зүйн хөтөчийн булангаар үйлчлүүлж байгаа иргэдэд Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль,гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, санал өргөдөл гомдлын тухай хууль, зөрчлийн тухай хуулиар мэдээлэл бэлтгэн гарын авлага тараан Орхонтуул ЗДТГ, Рашаант тосгоны захирагчийн албаны фэйсбүүк хуудсанд байршуулсан.

**Улсын бүртгэл:** Улсын бүртгэлийн ажил үйлчилгээний хүрээнд : 12-р сард Шинэ төрсөн-2, Нас барсан -3, Гэрлэлт-0, Шилжиж ирсэн-2, Лавлагаа – 28, Дахин гэрчилгээ-1, Иргэний үнэмлэх: шинэ-3, Сунгалт- 7, Дахин -0, Олголт- 10, Газар-0, Үл хөдлөх –1 нийт 57 бүртгэл хийж үндсэн мэдээллийн санд оруулан баталгаажуулсан байна.

**Нийгмийн даатгал:** 2021 он 12 дугаар сард Нийгмийн даатгалын төвлөрсөн санд-32145.8, ЭМД-ын санд-1605.5 мян.төг, Нийгмийн даатгалын Сайн дурын даатгалд- 5 малчин ,1 ажилгүй иргэн, Тэтгэвэр 593 иргэнд 226452.2мян төгрөг, Ажилгүйдлийн тэтгэмжинд-1 хүнд 594.3 мян тус тус олгон ажиллалаа. Харилцагч банкаа солиулж өөрчлүүлэхээр хүсэлт-5 шийдвэрлэсэн. Тэтгэвэр шинээр тогтоолгох хүсэлт гаргасан-3, тэжээгчээ алдсаны тэтгэвэр-1, нөхөн даатгалд-7 хүнийг тус тус шийдвэрлэн ажиллалаа.

**Татварын чиглэлээр:** Сум болон аймаг улсын төлөвлөгөөний хуваарийн дагуу 11 сарын төлөвлөгөө болон гүйцэтгэл өссөн дүнгээр 12 дугаар сарын 23-ны байдлаар улс-29532,2 мян/төг төвлөрүүлэхээс 36245,2мян/төг төвлөрч 118.5%, аймагт-165843,0 мян.төг төвлөрүүлэхээс 145336,3 мян.төг төвлөрүүлж 88,6%, суманд 60031,5 мян.төг төвлөрүүлэхээс 132256,4 мян.төг төвлөрүүлэн 220,6% гүйцэтгэлтэйгээр ажиллалаа.

**Газар зохион байгуулалт:** Газар өмчлөх хүсэлт ирүүлсэн 3 иргэний өргөдлийг хүлээн авч 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд оруулсан. Газрын эрх шилжүүлэх 1 иргэний 4 нэгж талбар газрыг шилжүүлж ажиллалаа.

**Нийгмийн халамжийн үйлчилгээ:** Энэ оны 12-р сарын байдлаар Нийгмийн халамжийн сангийн Халамжийн тэтгэвэрийг 31 иргэнд 8786,0 мян/төгрөг , Тэжээгчээ

алдсаны тэтгэвэрийг 8 иргэнд 2650,0 мян/төгрөг, Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй нийт 35 иргэнд 3335,0 мян / төгрөгийг тус тус олголоо.Халамжийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлснээр үйлчилгээг цахимаар бүртгэж,доорхи үйлчилгээнүүдийг иргэдэд хүргэж ажиллалаа.

Үүнд: Жирэмсэн эхийн тэтгэмжид 3 эхийг шинээр хамруулж , нийт 32 эхэд 1600,0 мян/ төгрөг , Цалинтай ээжийн тэтгэмжид 1 эхийг шинээр хамруулж , нийт 85 эхэд 4250,0 мян,төгрөг олгов.

### **Хоёр.НИЙГМИЙН БОДЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР:**

2021 оны 12-р сарын 19-ны өдөр сумын төв болон Рашаант тосгоны хамтарсан багийн нийт гишүүдэд Хамтарсан баг чадавхжуулах сургалтыг ГБХЗХГазар, Ундраа багштай хамтран зохион байгуулж ажиллалаа. Хамтарсан багийн самбар хийж нийт гишүүдийг хавтасжуулж ажиллалаа.

### **Гурав. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР:**

1, 2, 3 ээлжинд ирсэн нийт **71500** тун вакциныг нийт 586 өрхийн 23882 үхэр, 58265 хонь, 40984 ямаа, 364 гахай нийт 123475 толгой мал, амьтныг вакцинжуулалтанд хамруулсан бөгөөд бог тун 97763мл, үхэр тун 47764мл нийт 145527 мл тун /хорогдол 1079мл/-г зарцуулсан байна.

Голомтын болон сэжигтэй бүсийн 45 айл өрхийн малын хашаа, өвчтэй малын бэлчээр болон тоног хэрэгслийг тусгай зориулалтын ариутгалын ДУК автомашинаар НИСОР нэрийн бодисоор бүрэн халдваргүйтгэж ажилласан бөгөөд ариутгалын машин 2021 оны 11-р сарын 14-ны өдрөөс Орхон суманд ажиллахаар явсан болно. Өнөөдрийн байдлаар нийт өссөн дүнгээр 90900м2 талбайд ариутгал, халдваргүйжүүлэлтийг хийсэн.

Одоогийн байдлаар ГХШтаб, Мэргэжлийн баг байгуулан ажилласан өдрөөс эхлэн хүнсэнд 2,853,735, ариутгал халдваргүйтгэл, хамгаалах хувцас хэрэгсэлд 2,575,300 төгрөг, шатахуунд 6,839,652 төгрөг, нийт **12,268,687** төгрөгийн зардал гаргасан байна.

Одоогийн байдлаар вакцинжуулалтанд хамрагдаагүй үлдсэн 194 малчин болон мал бүхий өрхийн 163428 толгой малыг нэн даруй хамруулах шаардлага байна.

### **Дөрөв.ТӨСӨВ САНХҮҮГИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

2021 оны 12-р сарын 01-нээс 12-р сарын 24-ныг хүртэлх хугацаанд тус сумын Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжилт авдаг байгууллага болох сумын ЕБСургууль, Рашаант ЕБСургууль, Орхонтуул ЭМТөв, Рашаант ЭМТөв зэрэг төсөвт байгууллагууд, ЗДТГазар Соёлын төв, ИТХурал, Рашаант захирагчийн алба, Рашаант Соёлын төвийн үндсэн болон нэмэлт санхүүжилтийн данснаас 433,061,950 мянган төгрөгийн ажил гүйлгээг 288 ширхэг төлбөрийн хүсэлтээр ЗГУМСистемд шивж баталгаажуулж ажиллалаа.

Төсөвт байгууллагууд албан бичгийн дагуу ЗГУМСистемд хийх ажил гүйлгээг эрэмбэлж, анхан шатны баримтын бүрдэл бүхий баримтаар гүйлгээ хийгдсэн байна.

ТАЙЛАН БИЧСЭН:

ТӨРИЙН ЗАХИРГАА, ХУУЛЬ ЭРХ

ЗҮЙН МЭРГЭЖИЛТЭН

Ж.УНДАРМАА

ТАНИЛЦАЖ, ХЯНАСАН:

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН

ГАЗРЫН ДАРГА

Ш.ӨНӨРБАЯР